



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 24 өдөр


Дугаар А/173

Улаанбаатар хот

Г.Индарьяаг сургалтад  
хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдах “Монгол–Хятадын чөлөөт худалдааны хэлэлцээр-2019” сургалтад тус албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн Ганзоригтын Индарьяаг 2019 оны 06 дугаар сарын 24-нөөс 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд хамруулсугай.
2. Г.Индарьяад дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.
3. Г.Индарьяагийн ажлыг орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хариуцуулж, эзгүй байх хугацаанд нь ажил үүргийн хэрэгжилтэд биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаад даалгасугай.
4. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Г.Индарьяад даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

